



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 18 өдөр

Дугаар Б/13

Ховд

Б.Болормааг албан тушаалд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 23.2.3 дахь заалтуудыг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1.Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах зорилгоор Б.Болормааг аймгийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн туслах, гэрээт ажилтнаар 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.Б.Болормаагийн цалинг Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээний ТҮ-3-5 шатлал буюу 550324 төгрөг /Таван зуун тавин мянга гурван зуун хорин дөрөв /-өөр цалин бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/ -д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД